

МОДЕРН УРЛАГТ УРАН БҮТЭЭЛЧИЙН ИТГЭЛ ИЛРЭХ НЬ

Ж. Анунаран *

Түлхүүр үгс: сэтгэл, сэтгэлзүй, бүтээл, дүрслэл

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа л өөрсдийгөө болон алив зүйлсийн учир шалтгааныг мэдэхийг хүссээр иржээ. Энэ нь урлагт хэдэн мянган жилийн турш илэрч, хөгжсөөр XIX зууны дунд үе болоход дүрслэл, илэрхийллийн олон арга барил, изм үүсэхэд хүргэсэн байна. Уран бүтээлчийн сэтгэлгээ хийгээд, психологийн асуудал урлагт илэрч, дотоод ертөнцийн тухай томруун өгүүлэх болсон нь урлан бүтээх өргөн боломжыг олгох болжээ. Ийнхүү урлагт олон талын шинэ ойлголт, сэтгэлгээний хэлбэр бий болж, бүтээх үйл явцыг тайлбарлах үндэслэл, эстетик¹-ийн тухай ойлголт ч шинэ түвшинд гарч, хүний оршихуй болоод мэдрэхүй урлагт голлож, гүйцэтгэл, тавил дэг, сэтгэлзүйн асуудал хөндөгдөх болсон түүхтэй. Модернэгийн үед сонгодог урлагийн хөгжил саарч шинэ чиг хандлага дэлгэрч, 40 орчим урсгал үүссэн ба тэд дүрслэн илэрхийлэх, арга барил, хэв маягаараа хоорондоо ялгарч өөр өөрийн ойлголт, үзэл уриатай байсан бөгөөд өмнөх үеийнхээ уламжлалыг үгүйсгэхийн хамт тэр хөрсөндөө суурилан үүссэн байдаг.

Аливаа цаг үе, нийгмийн байдал тухайн үеийн уран бүтээлчийн сэтгэлзүй, уран бүтээлд нөлөөлж байдаг нь илэрхий. Гагцхүү тэр цаг үе нийгмийн байдлыг хэрхэн хүлээн авч, яаж илэрхийлэх нь уран бүтээлч бүрийн сэтгэлгээнд суурилдаг. Модернэгийн үед ертөнцийг харагдаж буйгаар бус, харахыг хүссэнээрээ басхүү хүсэл, бодол, мэдрэхүйгээрээ хандахыг эрхэм болгож байлаа. Модерн урлагт уран бүтээлчийн психик, сэтгэлзүй илүү тод илрэх болсон нь шинэ урлагт гарсан онцгой үзэгдлийн нэг байв. Үүнд итгэлийн тухай асуудал уран бүтээлчийн сэтгэлзүйгээр дамжин, бүтээлд тодорхой үүрэгтэй оролцох болсныг тэмдэглэх нь зүй. Уран бүтээлчид ялангуяа орчин үеийн хэл хэллэг, дотоод ертөнцийг илт илэрхийлэх Модернист уран бүтээлчдийн бүтээлийн өгүүлэмж бүр дотоод ертөнц, хувь хүн рүү чиглэх болж ямар ч сэдэв, хаалт үгүйгээр ил гарсан байдаг. Тэр бүрт уран бүтээлч хувь хүний туршлага, амьдралыг туулсан замнал зэрэг нь тухайн уран бүтээлч бүрийн итгэлтэй зайлшгүй холбогддог. Итгэлийн тухай ухагдахууныг товч авч үзэхэд Латин хэлний *Fid, fides, credo* гэдэг үгнээс гаралтай ба зээл, зээлээр өгөх, кредит гэсэн утгыг илэрхийлдэг. Англи хэлэнд *trust* гэж хэлэгддэг. Итгэлийг нийгмийн хүрээнд авч үзвэл гэр бүл, найз нөхөд, албан байгууллага, нэгдэл, компани, улс үндэстэнг хамарсан харилцаа дахь салшгүй шинж чанартай бөгөөд бодол санаагаа илэрхийлэхэд хүний харилцааны үндэс суурь болдог.

* МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим

¹ Гоо зүй

Биологийн ухаанд итгэл нь окситоцин² дааврын нөлөөгөөр өөрчлөгддөг³. Окситоцин даавар хүний итгэлийг нэмэгдүүлдэг болохыг тогтоожээ.⁴⁵⁶ Харин сэтгэл хөдлөлийн үр дүнд хүний итгэлийн шинж тэмдэгүүд илэрдэг. Нийгэмд итгэлийн тухай ойлголт хэд хэдэн утгатай⁷. Итгэлийн тодорхойлолтод⁸⁹ нэг тал нь итгэл нөгөө тал болох итгэмжит үйлдэлд найддаг. Энэ нь шууд ирээдүйд нөлөөлөх ба өөрийн мэдэлгүй итгэлтэй байдлуудаа хяналтгүй, чөлөөтэй үзүүлдэг. Хэрвээ итгэлтэй байдал нь хүсч буй байдлыг үзүүлэхгүй бол уналтанд орох, итгэлээ гээх хоёрдмол байдалд ордог. Харин нийгмийн болон сэтгэл судлалд итгэгч тал нөгөөдөө хүнлэг, үнэнч, шударга ухааны хэмжүүрболдог. Тухайлбал, “Өөртөө итгэлтэй байдал” нөгөө талдаа бүрэн үнэмшлийг олгодог. Мөн эдийн засгийн итгэл нь ихэвчлэн итгэлтэй үйл ажиллагаа дээр суурилдаг. Бүх талаараа итгэл нь логик шалтгааны хийсвэрлэлийг шаардах, хейристик шийдвэр, хүний нарийн зүйлтэй харьцах боломжыг нээдэг гэжээ.

Модернэгийн үед хамаарах Мексикийн Сюрреалист зураач эмэгтэй Фрида Кахлогийн хувьд нийгмийн бус цэвэр хувийн мэдрэмжээ бүтээлдээ илэрхийлж байсан нь өөрийн дотоод итгэл үнэмшлээр хандаж, бүтээн туурвиж байсныг илтгэнэ. Дотоод, гадаад харилцан үйлчлэлээс хамааран итгэл нь өөртөө хөгжлийг бий болгодог¹⁰. Тэрээр амьдралынхаа туршид өвчин шаналалаас салаагүй юм. Анх 6 настай байхдаа полимиелитийн вирус өвчнөөр 9 сарыг орондоо өнгөрөөсний эцэст хөл дээрээ босчээ. Тэрээр 15 настай байхдаа Диего Риверагийн Бэлтгэл сургуулийн амфитеатрт 1922 онд бүтээсэн ханын зургийг гайхашран, гүн гүнзгий мэдрэмж авснаар урлаг амьдралынх нь гол зүйл болсон байна. 1925 онд Кахло автобусны осолд орж, биеийнх нь олон тооны яс хугарч, 9 сарын турш гипсэн корсеттэй хөдөлгөөнгүй эмнэлэгт хэвтжээ. Түүний зовлонг амьдралаа бүтээлч хандлага болгосныг, шинжлэх ухаанд неоробиологийн бүтэц, хүний тархины үйл ажиллагаагаар хүн байгалиасаа итгэх, итгэлийг үнэлэх шинжтэйг нотолсоноор тайлбарлаж болох талтай. Удаан хугацааны эмчилгээний явцад жижиг хэмжээний автопортрет хийж, хүнд хэцүү эмчилгээгээ байнга тэвчиж байв. Фридагийн эхэн үеийн зургийн сургуулилт холимог, хутгамал шинжтэй байсан. Ослоос үүдсэн гэмтэл түүнийг хамгийн чухлаар, хувь хүний ганцаардал, үхэл, дотоод ертөнц

² Тархин дахь өнчин тархины хэсэгт боловсордог даавар ба олон нийтээр окситоциныг тэврэлтийн даавар, ёс суртахууны молекул, аз жаргалын гормон гэж нэрлэх болсон.

³ Kosfeld, M., Heinrichs, M., Zak, P. J., Fischbacher, U., and Fehr, E. (2005), "Oxytocin increases trust in humans" *Nature* 435, 673-676.

⁴ Theodoridou A, Rowe AC, Penton-Voak IS, Rogers PJ (June 2009), "Oxytocin and social perception: oxytocin increases perceived facial trustworthiness and attractiveness". *Hormones and Behavior*. 56 (1): 128-32.

Cardoso C, Ellenbogen MA, Serravalle L, Linnen AM (November 2013). "Stress-induced negative mood moderates the relation between oxytocin administration and trust: evidence for the tend-and-befriend response to stress?". *Psychoneuroendocrinology*. 38 (11): 2800-4.

⁵ Lane A, Luminet O, Rimé B, Gross JJ, de Timary P, Mikolajczak M (2013). "Oxytocin increases willingness to socially share one's emotions". *International Journal of Psychology*. 48 (4): 676-81.

⁶ Cardoso C, Ellenbogen MA, Serravalle L, Linnen AM (November 2013). "Stress-induced negative mood moderates the relation between oxytocin administration and trust: evidence for the tend-and-befriend response to stress?". *Psychoneuroendocrinology*. 38 (11): 2800-4.

⁷ McKnight, D. H., and Chervany, N. L. (1996). The Meanings of Trust. Scientific report, University of Minnesota.

⁸ Mayer, R.C., Davis J.H., Schoorman F.D. (1995). An integrative model of organizational trust. *Academy of Management Review*. 20 (3), 709-734.

⁹ Bamberger, Walter (2010). "Interpersonal Trust – Attempt of a Definition". Scientific report, Technische Universität München. Retrieved 2011-08-16.

¹⁰ Hardin, R. (eds.) (2002). *Trust and trustworthiness*. Russell Sage Foundation.

зэрэг оршихуйн асуултуудыг төрүүлж, тэр бүгдтэй нүүр тулсан байна. Тэрээр хувь хүний эмгэнэлт байдлаа бие болон сэтгэлзүйн шинж голлосон реалистик зургийн аргаар илэрхийлдэг нь хүүхэд байхдаа аавынхаа фото студид жижгэвтэр нарийн нямбай, чимхлүүр ажиллагаатай ажлуудыг хийж сурсантай нь холбоотой. Нөгөөтэйгүүр Үндэсний бэлтгэл сургуульд байхдаа Фернандо Фернандесийн студид зургийн боловсролыг эзэмшсэн зэрэг нь этгээд сонин дүрслэл рүү хөтлөх эхний алхам байв. Фрейдийн онолд “Урлаг нь уран бүтээлчийн сэтгэлгээ дахь үнэн мөн чанарыг шууд буулгадаг” гэснээс хөөвөл Кахлогийн бүтээлд өөрийн үнэнг илчилсэн хөрөг зонхилох ба ихэвчлэн сэтгэлийн шаналалаа үзүүлдэг. Бүтээлд гол төлөв дүрслэлд өвдөж байгаа газар, сэтгэл зовоосон зүйлийг харуулдаг. Фрида Кахлогийн “Өргөстэй хүзүүний зүүлт болон калибр шувуу” (Зураг-1) бүтээлээр жишээлэхэд, ширэнгэд зогсох, цагаан хувцастай эмэгтэйдээр хувь хүний дотоод ертөнц болон бие дээрээ туулсан, мэдрэсэн гэх хоёрдмол шинж харагдана. Эмэгтэй цагаан цамц өмсч, эрвээхэйнүүд түүний хар үсийг тогтоон барьжээ. Түүний хүзүүг усан үзмийн ороонго ороож, хар хэрээ дүүжлэгдсэн байна. Ар талд нь зэрлэг хар муур гэтэж, жижигхэн хар сармагчин хүзүүн дэх ороонгыг холбож сууна. Жижигхэн сононууд халуун орны ногоон навчин дээр болон эргэн тойронд нь нисч, цаанаас гэрэлтэх жижигхэн хөх тэнгэр үзэгдэнэ. Түүний аз жаргалгүй, нуугдмал хүслээ байгаль руу зугтаж буйгаар илэрхийлсэнийг магад Фрейд тайлбарласан байж болох юм. Кахло зэрлэг муурны хамааралд байгаа, хүсэл тэмүүлэл нь өвчинд нэрвэгдсэнийг, хүзүүтээр нь усан үзмийн ороонго, мич ороосон зэрэг нь цагдан хорих мэдрэмж, нийгмийн хоригоос суллагдах хүсэл гэмээр. Фрейд уг зургийн талаар уран бүтээлчийн үнэн сэтгэл хөдлөл, биелээгүй хүсэл мөн сэтгэл зүйн эмгэг, сэтгэл санааны хурцадмал хэлбэрүүд үзэгдэж байгааг дурдсан нь уран бүтээлчийн амьдрал, урлагийг бүтээх, бүтээлтэйгээ шууд хамааралтай болохыг баталж буй юм. Кахлогийн олон бүтээлийн утга санаанд Герман, Мексик үндэсний онцлог шинж, түүний нөхрийн национализмын хүчирхэг бүтээлүүд, Мексик үндэсний эмэгтэйн үүрэг, эхнэр байх зэрэг харагддаг. Үүнд 1927 онд Мексик хотын уран бүтээлийн болон Коммунист хөдөлгөөнд холбогдож, 1928 онд албан ёсоор Мексикийн Коммунист бүлгэмд нэгдэж байсан нь нөлөөлсөн байна. Кахло хэлэхдээ, “Миний амьдралд хоёр том осол байсан. Нэг нь автобус, нөгөө нь Диего”¹¹ гэснээс үзвэл хувь тавилангийн эрхээр эдэлсэн шаналал нийгмийн бус, цэвэр хувийн шинж бүхий сэтгэлзүйн өнгөтэй байсан нь илэрхий.

Гагцхүү бүтээлийн агуулга болоод субъектын харилцаанд, бүтээлчийн дарангуйлагдсан хүсэл, дотоод зөрчил, ялангуяа бүтээлч эрэлхийлэлд судлаачид ихээхэн анхаарал хандуулдаг. Ер нь биелээгүй хүслийн эрчмээ уран бүтээлийн дүрд хувиргах (ухамсарт үйлдэл болгох) явдал зураач бүрт чухал. Орчин үеийн психоаналитикчид зураачийн бодол хийгээд дотоод ертөнц нь бүтээлд товойн гарч ирдэг гэж үзсэн аж. Ийнхүү ямар ч урлагийн бүтээл нь зураачийн нууц ертөнц болон ухамсар дахь доод ухамсартай шууд хамаатай болохыг илтгэнэ. Урлаг судлалын онолд психоанализын судалгааг херменевтик, семиотик структурализмтай нэг түвшинд авч үздэг болсон нь уран бүтээлийг задлан шинжихэд ихээхэн тустай юм. Тэр тусмаа уран бүтээлч ямарваа нэг биелээгүй хүслийн энергийг өөр зүйлд хандуулбал, тэр нь өөрийгөө илэрхийлэх хүчтэй түлхэц болдгийг Фридагийн гүнзгий мэдрэмж бүхий далд утгатай хөрөг зургуудаас харж болно. Фрейд үзэхдээ “Мөрөөдөгч ба бүтээлч хүний

¹¹ Gene A Mittler. Art in Focus., 1994. P. 546

дунд гүн гүнзгий ижил зүйл оршиж байна. Гэхдээ тухайн нөхцөлд төрөн гарч байгаа бүтээл ба зөгнөл нь ялгаатай. Энэхүү ялгаа нь сублимацийн үзэгдлийн үндэслэл юм”¹² гэжээ. 1930 оны эхээр, Кахлогийн бүтээлд илүүтэйгээр Мексикийн модернист индианист¹³ хөдөлгөөний нөлөө илэрч байв. Тэрээр Европын фашизмын үед хөгжиж байсан Мексикандад¹⁴ сэргэлтийг мөн дэмжиж байлаа. Кахло 1930 онд Мексикийн үндэсний илэрхийлэлтэй *ex-voto*¹⁵ бүтээлд амьдралын туршлага, хатуу чанга, сайхныг зэрэг дүрсэлсэн нь хоёр удаа зулбасантай нь холбоотой. Вотив зургийг Мексикт хэд хэдэн янзаар нэрлэх ба нийтлэг нэр нь *ex voto* буюу латин үгний тангараг гэсэн утгатай. Уг зургийн зорилго нь өчиг өгөх, бурханд талархалаа илэрхийлэх юм. Вотив зурагт ихэнхдээ гай зовлон, өөрийн өвчин, гомдлыг харуулсан, гуйлт хүсэлтээ илэрхийлж, шашны хүнээр тангаргийг биелүүлэхээр сүм болон бусад ариун газар авчирдагаас үвэл түүний вотив зураг өөрийн амьдралд болсон бүхнээ өчижээ. Хэдий, Сюрреализмын албан ёсны гишүүн бус ч Кахлогийн этгээд дүрслэл, шулуун хэв маягай ч хошин эсвэл сэтгэхүйн төлвөөс илүү гүн гүнзгий дүрслэл хувийн шинжээрээ ялгардаг. Кахлогийн хувьд зүүд болон ухамсаргүйгээс ирэх зүйлс сонирхолтой байгаагүй нь “Би ихэнхдээ өөрийгөө зурдаг, учир нь намайг хамгийн сайн мэдэх хүн нь би өөрөө...”¹⁶ гэснээс харагдана. Хүчтэй бие даасан ямар ч урлагийн урсгал чиглэлд автаагүй Кахлогийн бүтээлүүд примитивизм¹⁷, индигенизм, сюрреализмтай¹⁸ төстэй. Ийнхүү Модернэгийн үеийн гол шинж, тэр тусмаа уран бүтээлчийн бүтээлд сэтгэлзүй болон итгэл үнэмшил нь бүтээн туурвихад ямар үүрэгтэй оролцож байгааг Фридагийн бүтээлүүд тодорхой илтгэнэ.

Модерн урлагийн нөлөө манай оронд ч мөн тусгалаа олсон билээ. 1990 оны ардчилсан хувьсгалын дараа Монголд капиталист буюу хөрөнгөтний урлаг дэлгэрсэн хэмээн үздэг ч Модерн өгүүлэмжтэй бүтээл социализмын үед ч байсан юм. Ардчиллын нөлөөгөөр Модерн буюу шинэ сэтгэлгээний урлаг орж ирснийг үгүйсгэхгүй ч социалист нийгмийн үед шинэ сэтгэлгээний урлаг мэр сэр гарч тухайн нийгэм цаг үеийнхээ шахалтаар хэлмэгдэн хаагдаж байв. Тухайлбал, залуу уран бүтээлчдийн үзэсгэлэнд Төрийн шагналт зураач О.Цэвэгжав, Прагийн үйлдвэр урлалын сургуулийн төгсөх курсын оюутан П.Балдандорж, Г.Соосай, Г.Дунбүрээ тэргүүтэй уран бүтээлчид оролцож, П.Балдандорж “Хөвсгөл нуур”, О.Цэвэгжав “Эхийн цагаан сэтгэл” бүтээлээ дэлгэсэн түүхтэй. 1968 онд нефть ачсан усан онгоцны чиргүүл нууранд унаж, Хөвсгөл далай тэр чигтээ аюулд учирсан явдлын дараа уран бүтээлчийн харамссан сэтгэлээс “Хөвсгөл нуур” бүтээл төржээ. Түүнийг улс төрийн товчоо Социалист уриан дор нэгдэж, нийгмийнхээ хөгжлийн талаар чин эрмэлзлэлийг тусгах реалист хэлбэргүй

¹² Фрейд З. Художник и фантазирование. М., 1995. С 130

¹³ Индианизмыг баримтлагч

¹⁴ Мексикийн үндэсний хөдөлгөөн

¹⁵ Экс voto буюу Вотив нь шашны эсвэл гомдоллын дүрслэлтэй, ивээл өршөөл эрсэн болон гайхамшигийг үзүүлсэн жижиг хэмжээний зураг юм.

¹⁶ Andrea Kettenmann. Frida Kahlo., 2014.p 27

¹⁷ (лат. Primitives-анхны, хамгийн эртний) Зориуд, санаатайгаар уран сайхны дүр, эд зүйлсийг хялбарчилж, болхи, гэнэн хэлбэр, өнгө аястай дүрсэлдэг энэхүү чиглэлээр мэргэжлийн болон мэргэжлийн бус зураачид бүтээдэг. Ардын мэргэн сэтгэлгээ, хүүхдийн гэнэн цайлган нүдээр бүтсэн баяр баясгалантай, энгийн илэрхийлэлтэй.

¹⁸ (фр.Surrealism-хэтэрхий бодит) Францын Анри Бергсон, Германы Вильгельм Дильтэй, Австрийн Зигмунд Фрейд нар сэтгэл зүйн онолд тулгуурласан сюрреализм 1919-1924 онд утга зохиол, 1924-1929 онд дүрслэх урлаг, кино, театрт хүч түрэн орж ирсэн.

бодит байдлаас хэт зөрүүтэй төдийгүй, “ардач”, “намч” шинж чанаруудаа алдаж хэтрүүлэгтэй хоосон дүрслэлтэй хэмээн шүүмжилсэн байна. О.Цэвэгжав “Эхийн цагаан сэтгэл” бүтээлдээ эхийн хайрыг дүрслэхдээ хүүгээ тэвэрсэн эхийг уламжлалт хэлбэрээр илэрхийлэх бус уламжлалт зан заншил, сэтгэлгээн дахь бэлгэдлийн элементийг хэллэг болгон ашиглаж, бүтээл дэх хэллэгүүдэд дүрслэл цэвэр өнгийн тоглолыг ашиглажээ. Байгаль дэлхий, тэнгэр, газар, сүүн цагаан сэтгэл гэх Монгол хүнд ойр үндсэн ойлголтыг багтааж, тойм өнгө дотор шийдсэн. “Энэ зурагт эхийн энэрэл, байгаль ертөнцийн холбоог хийсвэр дүрслэлээр гарсан нь онцлог юм. Зураач эхийн цагаан сэтгэлийг босоо дөрвөлжин хэлбэр дотор цагаан өнгөөр төлөөлүүлэн авсан бол хэвтээ шулуун дэвсгэр дээр хар ногоон, маргад ногоон өнгийн дагнаасаар газрыг авсан. Ногоон өнгө дэлгэрч цэцэглэхийн бэлгэдэл хэдий ч, мөн хорвоогийн амьдралын хатуу зөөлөн, хар, цагаан, эрээн барааныг хар ногоон, маргад ногоон дунд ургамлын тунгалаг ногоон өнгө оршин буй мэтээр нэг өнгийн олон ялгарлаар төлөөлүүлж гаргажээ. Тэр бүгдийг эхийн цагаан сэтгэл туулж хөх тэнгэрийн дор оршиж хүмүүний амьдралын тулгуур багана болон оршин байдгийг газраас тэнгэр өөд тэмүүлсэн босоо цагаан дөрвөлжинд авчээ”¹⁹ гэжээ. Сэтгэл зүрхээ дагасан эхийн хайраа бүтээлдээ илэрхийлсэн бүтээлчийн чөлөөт оролдлогын илрэл тухайн үедээ урьд өмнө үзэгдэж байгаагүй цоо шинэ үзэгдэл болсон ч хөрөнгөтний урлаг хэмээх шүүмжлэл хүлээсэн буй. Харин 1990-ээд оноос хойш Монголд Модерн урлаг хөгжихөд нэлээд уран бүтээлчид хувь нэмрээ оруулсан байдаг. Тэд “Ногоон морь” хэмээх бүлгэмийг байгуулж, өөрийн уриаг дэвшүүлж байсныг дурдах нь зүй. Ян Финдли-Браун “Уламжлал ба орчин үеийн тухай” шүүмжид “Уламжлалт соёл, ёс заншлаа хадгалсаар байгаа ч өнөөгийн дэлхийн хөгжилтэй хамт явж буй орны өнгөрсөн болоод одоог холбосон гүүрийг урлагаар бүтээж хүний сэтгэлд хүргэнэ гэдэг амаргүй асуудал. Тэр тусмаа өнгөрсөн 60 жилийн хугацаанд соёл уламжлал нь нийгэм улс төрийн хүчтэй өөрчлөлтүүдэд арчигдахыг үзсэн монгол зураачийн хувьд энэ нь бүр ч хүндрэлтэй байж болох юм.”²⁰ хэмээн зураач Ш.Чимэддоржийн талаар дурьджээ. Уран бүтээлчийн олон сэдэв дотроос түүний сэтгэлийг хөдөлгөдөг хүүхдийн гэнэн дүрслэл чухал байр эзэлдэг. Түүний амьдралд тохиолдсон хэцүү бэрх үеийг мөн л өөрийн бүтээлч эрчим болгон илэрхийлсэн нь амьдралын үнэт зүйл хайр, дурсамж, санаашрал зэргийг буулгах мэт, хүүхдийн цагаахан төсөөллөөр өрнөдөг. Түүний өнгөний тунгалаг мэдрэмж, гэнэн цэвэр зураас, илэрхийлэх чадвар нь онцгой. Тэрээр охиныхоо хөргийг баялаг өнгө, өхөөрдөм дүрслэлээр илэрхийлжээ. “Түүний ийм сэдэвтэй бүтээлд ихэвчлэн хөх өнгө давамгайлж, зохиомжийн ихэнх хэсгийг өнгөөр үлдээдэг нь уудам талд мэдэрсэн их орон зайг төлөөлүүлсэн хэрэг. Өнгө бол түүний бүтээлд зөвхөн сэтгэл хөдлөлөөс гадна уянгын өвөрмөц чанарыг нэмдэг”²¹ байна.

Ш.Чимэддоржийн “Галт шувуу” (Зураг-2) бүтээлийн цулгай бичсэн хөх өнгө мөнх хөх тэнгэр бэлгэдсэн уламжлалт сэтгэлгээний өнгөөр илэрхийлэл гэлтэй. Хөх өнгө охины дүрийг улам тодотгох ба хязгааргүй орон зай, огторгуйн мэдрэмжийг тусгаж материаллаг ертөнцөөс ангид, агаарт мэт, энэ ертөнцийн биш мэт хүүрнэлтэй. Магад уран бүтээлчийн сэтгэлд өөрийн эрхгүй дүрслэгддэг өнгийн хязгааргүй шинж, орон зай цаг хугацаанд хамааралгүй мэт агаарлаг мэдрэмж охины бодитоос салсан сэтгэгдлээс эхтэй. Агаарлаг хүүрнэмж дунд баялаг ертөнцийн өгүүлэмж дүүрэн агаад зургийн төвд

¹⁹ Ц.Эрдэнэцог. XX зууны Монголын уран зургийн өнгө зохицол, УБ., 2006. Тал 44


²⁰ Sh.Chimeddorj. Sunrise in the Blue World., 2014. p.001

²¹ Мөн тэнд. p. 002

буй бяцхан охин ганцаараа ямар нэг дуртай зүйлээ хийж, тайвнаар дүрслэгдсэн байна. Аз жаргалгүй гэхээс илүү бодлогоширсон төрх ажиглагдана. Ш.Чимэддорж охиныхоо талаар өөрийн номондоо дурдсан байдаг. “Бид томоо болсон охиноо алдаж, хорвоогийн хатуу, гашуун тэр бүхнийг бие сэтгэлээрээ эдэлсэн юм. Зураг их зурдаг, уран торгон авъяастай тэр охиноо үгүйлж гансрахдаа би хүүхдийн сэдэвтэй зураг мөн ч их зурсан даа. Тэр сэдэв миний уран бүтээлд бас их чухал байр суурь эзэлнэ. Охиныхоо зурсан зургууд дээр үндэслэн баяжуулж зурна. Энэ бол охиныхоо зургийг хуулж байгаа биш, бурханы зарлигийг гүйцэлдүүлж байгаа хэрэг гэж ойлгодог...”²² гэжээ.

Урлагийн түүхэнд гарсан Модернизмын хөдөлгөөн хүн төрөлхтний хувьд аливааг өөрөөр харах, таних эргэлтийн үе байсан бөгөөд урлагт өөрийн ул мөрийг үлдээсэн. Монголын Модерн урлагийн үе мөн нийгэм цаг үеийн эргэлт, хүмүүсийн үзэл бодол өөрчлөгдөж эхэлсэн үеэс хүний дотоод сэтгэлийн давтамж, хөдөлгөөн бүр энэ үеийн урлагаас эхлэлтэйгээр сэтгэлзүйн асуудлыг хөндөн урлагт илэрхийлэх, гадаах бус дотоод ертөнцийг сонирхон шинжих сэдэл, уран бүтээлчийн итгэлийн тухай асуудал урган, нийгмийн захиалгат шинжээс ангид оршихуйн өөрөөрөө байх тэр л илэрхийллийг олсон нь энэ үеийн урлагийн эргэлт бөгөөд уран бүтээлчид өөрийн дотоод ертөнцийг илт илэрхийлэх болсноор шинэ зүйл рүү хөтлөх алхам болжээ. Итгэл нь уран бүтээлчийн амьдралын тусгал бөгөөд итгэлээр дамжин уран бүтээлч өөрийн оршихуйн асуудлыг хөнддөг бөгөөд магад түүгээрээ илүү хүнлэг, бүтээлч, урлагаар хүмүүжих, ухааруулах чанарыг хадгалдаг буй. Уран бүтээлчийн амьдралд итгэл чухал байр суурь эзлэх бөгөөд итгэлийн олон шинж байдал, түүгээр дамжин бүтээл туурвих хамгийн том түлхэц болдог байна. Нэг талаар уран бүтээлчийн амьдралыг үзэхүй, итгэлээр дамжин илрэх бүтээл нь тухайн цаг үе, нийгмийг харуулах толь болж байдаг бол нөгөө талаар бүтээлчийн сэтгэлзүй болон итгэл, бүтээх нь салшгүй холбоотой зүйл болохыг харуулж байгаа хэрэг:

²² Мөн тэнд. р. 019



Зураг-1



Зураг-2

НОМ ЗҮЙ

1. Сосор О. Байгалмаа Б. (2006), Дэлхийн урлагийн түүх. УБ.,
2. Сосор О. (2014), Урлагийн чиг хандлага, УБ.,
3. Дагиймаа Ц. (2005), XX зууны манлай, Ардын зураач, Төрийн хошой шагналт Очирын Цэвэгжав, УБ.,
4. Уранчимэг Ц. (2007), XX зууны өрнөдийн урлаг, УБ.,
5. Эрдэнэцог Ц. (2006), XX зууны Монголын уран зургийн өнгө зохицол, УБ.,
6. Chimeddorj Sh. (2014), Sunrise in the Blue World.,
7. Фрейд З. (1998), Психоанализ. УБ., (орчуулсан М.Баяртогтох)
8. Gene A Mittler. (1994), Art in Focus.,
9. Фрейд З. (1995), Художник и фантазирование.М.,
10. [https://en.wikipedia.org/wiki/Trust_\(emotion\)](https://en.wikipedia.org/wiki/Trust_(emotion))
11. https://en.wikipedia.org/wiki/Frida_Kahlo

SUMMARY

The thesis mentioned about trust and it is meaning and origin. For example, why people trust each other, how it is expressed, what is the description on Religion, Philosophy, Sociology, Psychology and Art. The trust came from Latin word Fid, fides, and credo. It means that credit and faith. In Mongolian, it is described as honesty. In philosophy, trust is explained based on the knowledge. In psychology, trust is belief that the person who is trusted will do what is expected. It starts at the family and grows to others. In the art many expressed about of trust. For example, Mexican artist Frida Kahlo paintings painted using vibrant colors in a style that was influenced by indigenous cultures of Mexico as well as by European influences that include Realism and Surrealism. Many of her works are self-portraits that symbolically express her own pain and sexuality. Also in Mongolian Modern artist Sh.Chimeddorj's paints of children feature prominently in his many kind of themes. He painted many paintings in such a way as a child would paint which expressed his life faced a tragedy.